

6

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ҮНЭ ЦЭНЭ БА АЧ ХОЛБОГДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДЛУУД

Г. Элдэв-Очир, Б. Энх-Амгалан

Статистикийн тухай хуулинд статистик мэдээллийг: нэгдсэн хөтөлбөр, аргачлалын дагуу цуглуулж боловсруулсан эдийн засаг, байгаль орчин, нийгмийн холбогдол бүхий мэдээлэл гэж тодорхойлсон байдаг. Эндээс үзэхэд Статистик мэдээлэл нь улс орны хэмжээний бүхий л мэдээллийг хамарч байна. Энэ ч утгаараа аливаа судалгаа шинжилгээ хийж буй шинжээч, судлаач, мэдээлэл хэрэглэгч нарт тавьсан зорилгоодоо хүрэх үнэт материал нь болдог.

Дэлхий хөгжлийн хандлагыг дагаад мэдээлэл технологийн хэрэгцээ асар хурдацтай өсч байна. Тиймээс мэдээллийг богино хугацаанд зөв зохион байгуулалттайгаар шуурхай боловсруулж мэдээлэл хэрэглэгч нарт үнэн зөвөөр хүргэх нь статистик мэдээллийн ач холбогдлын гол шалгуур нь болдог. Энэ шалгуурыг давсан мэдээлэл нь улс орны хэмжээний төдийгүй аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн шийдвэр гаргалтад нөлөөлнө. Жишээлбэл бидний сайн мэдэх ҮНБ, ДНБ-ний мэдээнээс үндэслээд тухайн улсын эдийн засгийн чадавхи, улс орны хөгжлийн төлөв, гаднаас авах зээл, тусламжийн хэмжээ зэрэг шалтгаалж байдаг.

Статистик мэдээллийг хэрэглэгчдийн зүгээс санал бодлоо илэрхийлэхдээ ихэвчлэн шаардлагатай мэдээллээр хангагдаж чадаагүй, хэрэв мэдээллийн боломж илүү их байсан бол нарийвчилсан судалгаанд чухал нөлөө үзүүлэх байсан гэсэн санаа ажиглагддаг. Үүнтэй уялдаад мэдээллийн эрэлт нийлүүлэлтийн тухай асуудлыг хөндөх хэрэгтэй болно.

Зах зээл хөгжсөн орны хувьд чанартай мэдээллийн талаарх эрэлт өндөр байдаг. Өөрөөр хэлбэл уг мэдээллийн үнэ цэнэ өндөр байна гэсэн үг. Иймээс чанартай мэдээлэлд тодорхой үнэ төлөх арга зүйг болвсруулах нь зүйтэй. Энд ганц статистик мэдээлэл ч бус арилжааны шинж чанартай мэдээллүүдийг ч хамруулж ойлгож болно. Зах зээлийн зарчмаараа чанар үнэ цэнэгүй мэдээлэл борлогдохгүй учир тэдгээр байгууллагуудаас чанаргүй мэдээлэл гаргах шаардлагагүй болдог. Энд бас нэг чухал асуудал бол уг мэдээллийг хайх болон ашиглахад гарч болох бэрхшээлүүд байдаг. Тухайлбал:

1. Шаардлагатай мэдээлэл олж авах бололцоотой гэдэгтээ эргэлздэг

2. Хаанаас мэдээлэлээ авах вэ? гэдэг асуудал тодорхой бус
3. Мэдээлэл олж авах арга зам нь хүндрэлтэй
4. Мэдээлэл хэтэрхий үнэтэй
5. Мэдээлэл хуучирсан
6. Мэдээлэл хэт өргөн хүрээг хамарсан гэх мэт нь мэдээллийн эрэлтэд саад болох талтай.

Монгол улсын хувьд статистик мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэх нь зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөөгийн нөхцөлд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ зорилгыг шийдвэрлэхэд тус дөхөм болох үүднээс манай орон дэлхийн эдийн засгийн харилцаанд оролцох олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудад гишүүнээр элсэн орсон нь нэлээд том амжилт гэж хэлж болно.

Одоогоор мэдээллийг олон улсын стандартад нийцүүлэх талаар нэлээд ажлыг хийж зохих түвшинд хүрсэн боловч статистик мэдээлэл хэрэглэгчийн хэрэгцээг тэр бүр хангаж чадахгүй байна.

Манай өнөөгийн нөхцөлд хэрэглэгчдэд зориулсан статистик мэдээлэл гаргадаг хэдхэн байгууллага болох Үндэсний Статистикийн Газар, Байгаль Орчны Яам, Эрүүл Мэндийн Яам, Гаалийн Ерөнхий Газар, Монгол Банк гэх мэтийн хуруу дарам цөөхөн газар байгаа ч эдгээрийг холбосон нэгдсэн сүлжээ шуудхан хэлэхэд алга байна. Тиймээс энэ нэгдсэн сүлжээг байгуулахад Засгийн газар болон төрийн удирдлагын байгууллагуудын аль аль нь анхааралдаа авах шаардлага тавигдаж байна гэж үзэж байна.

Одоогоор эдгээр статистик мэдээлэл түгээж буй байгууллага нь internet-д өөрийн гэсэн web хуудастай энэ нь өөрийн байгууллагын зорилго, чиглэл, үйл ажиллагааг танилцуулах төдийхнээр хязгаарлагдаж, дотоод сүлжээгээр ойр зуурын хэрэгцээг хангахаас нэгдсэн мэдээллийн бааз болох боломж бүрдээгүй байна. Нэгдсэн сүлжээг байгуулсанаар наад зах нь статистик мэдээллийг хүссэн гадаад дотоодын ямар ч хэрэглэгч маань өөрийн кодтой болж төлбөрөө төлсөн тохиолдолд нэгдсэн сүлжээ рүү хандаж хаанаас ч хүссэн мэдээллээ авах боломжтой болох юм. Нөгөө талаар статистик мэдээлэл нийлүүлэгч байгууллага ч хөрөнгийн асуудлаар тодорхой хэмжээгээр улсаас харалгүй шийдвэрлэх боломж бүрдэнэ. Үүний зэрэгцээ уламжлалт арга болох эмхэтгэл, тайлан, бюллетень, танилцуулга зэргээ хэвлэмэл байдлаар тараахаас гадна CD эсвэл хэсэгчилсэн байдлаар floppy disk ашиглаад ч тарааж болно. Гадаадын судлаачид л гэхэд ихэвчлэн манай улсын талаарх мэдээллийг CD-р худалдан авах сонирхолтой ч тэр нь байдаггүй зэрэг хүндрэлтэй тал гардаг. Энэ нь зөвхөн гадаад ч биш дотоодын хэрэглэгч нарт ч хамаатай байгаа юм. Учир нь тэд нэгэнт мэдээллийн эх үүсвэрийг заасан байдлаар өөрийн судалгааны материалд дахин компьютерт шивж цаг алдалгүй шууд хуулж нэмэлт тайлбар судалгаа шинжилгээний үр дүнг гаргах харуулах сонирхолтой байдаг.

Статистикийн мэдээлэл цуглуулах аргачлалын холбогдолтой материал бүрдсэн боловч мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах хүрээнд хангалтгүй байдал ажиглагдсаар байгаа нь чанарын асуудалд муугаар нөлөөлж байна.

Мэдээллийн эх үүсвэрийг хамрах хүрээний хувьд орон нутагт аймаг, түүний харъяа сумууд байдаг. Тэгвэл сумдуудаас авах мэдээллийн эх үүсвэр нь мэдээллийг бүрдүүлэгчийн үүрэг, хариуцлага, мэдлэг боловсролоос ихээхэн шалтгаална. Мэдээллийн эх үүсвэрийг Статистикийн байгууллагын тодорхойлон гаргасан аргачлалаар сумуудын мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах ажлыг сумын орлогч дарга хариуцдаг. Өнөөгийн нөхцөлд сумуудын орлогч нар нь статистикийн мэдлэгээр хомс мэргэжлийн бус хүмүүс байдаг учраас мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажилд доголдол гарч байна. Ийм учраас анхан шатны мэдээлэл бүрдүүлэлтийн гажигаас дараагийн шатны мэдээллийн бүрдэлт харилцан адилгүй, мэдээллийн

эх үүсвэр хангалтгүй, зарим тохиолдолд нэгтгэх боломжгүй зэргээс мэдээллийн боловсруулалт үр дүнтэй биш байдалд хүрэх нөхцөл бүрддэг. Зарим үед тухайн нэгжийн үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийг буруу ташаа гаргах хандлага ч байхыг үгүйсгэхгүй. Эдгээрийг статистикийн хэлээр санамсаргүй ба санаатай алдаа гэж нэрлэдэг. Санаатай алдааг гаргах нөхөл нь тангараг өргөсөн төрийн албан хаагч үүргээ биелүүлээгүй, санамсаргүй гарах алдаа нь өөрийн ажлын мэдлэг, дадлага туршлага, өөрийгөө хянах хяналт зэргээс шалтгаална. Иймд орон нутагт ялангуяа сумын орлогч нарын мэдлэг боловсролыг системтэй дээшлүүлэх сургалт явуулах, дээд шатны сургуульд суралцуулах зэрэг дэс дараатай арга хэмжээ зүй ёсоор шаардагдаж байгааг анхаарах хэрэгтэй юм.

Энгийн нэгэн жишээ авахад байгаль орчны холбогдолтой нутаг дэвсгэрийн мэдээллийг маягтын дагуу гаргуулан авч үзэхэд манай орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнээс хэтэрсэн байж жишээтэй. Энэ нь өөрийн харъяа нутаг дэвсгэрийн хэмжээг мэддэггүй, заавар, маягтай муу танилцсан, мэдээллийг бүрдүүлэхэд хайхрамжгүй хандсан зэргээс шалтгаалж байгаа гэж хэлж болно. Эндээс үзэхэд анхан шатны мэдээлэл буруугаас шалтгаалж улс орон, гадаад орчинд цацагдаж байгаа мэдээлэл нь худал байж болохыг үгүйсгэх аргагүй болоод байгаа юм. Аймаг орон нутгаар хянагдаж боловсрогдсон мэдээллээр зогсохгүй төв дээр ирэн боловсруулагдсан мэдээлэл хоорондоо зөрчилдөх байдал ажиглагдсаар байна. Энэхүү алдаа, гажиг нь судлаачдын сэтгэлийг бухимдуулахад хүрэгдэг талтай. Тухайлбал олон жилийн динамик судалгаанд зарим үед хугацааны мэдээлэл ихээхэн зөрчилддөг. Жишээлбэл: Экспорт импортын мэдээллийг-ҮСГ, ГЕГ, Монгол банк зэрэг байгууллагуудын гаргасан мэдээлэл хооронд зөрчилдсөнөөс альныг нь баримтлах вэ? гэдэг асуудал гарч байгаа юм.

Тухайлбал Статистикийн эмхэтгэл, Монгол банкны тайлан, Annual report of Mongolian economic Review гэсэн гурван гол материалыг аваад үзье. Доорх материалаас харахад 1995 оны экспорт, импортын талаарх мэдээнүүд нь бүгд хоорондоо зөрчилдөж байна. Эмхэтгэлд тусгаснаар экспортын хэмжээ 473.3 сая ам долларын хэмжээтэй байхад, Монгол банкны тайланд 451.0 сая ам доллар, Annual report-д 485.6 сая ам доллар байгаа юм. Энэ нь дан ганц экспортод ч биш, импортод ч ийм байгаа юм. Гэхдээ энэ нь бусад статистик мэдээллүүд ч бас ажиглагдсаар байгаа юм (Доорхоос харна уу!).

14.2 ЭКСПОРТ, оны үнээр
14.2 EXPORTS, at current prices

Улсаар	By countries	1990	1995	1999*	2000
Бүгд	Total	660.7	473.3	358.3	466.1
Австри	Austria	-	0.1	0.0	0.0
АНУ	USA	0.9	25.8	46.3	92.9
Афганистан	Afghanistan	1.5	0.1	-	-
Болгар	Bulgaria	16.7	0.0	0.0	0.0
Бельги	Belgium	-	2.2	0.9	1.6
БНСУ	South Korea	-	26.1	2.1	2.7
БНАСАУ	North Korea	1.8	0.1	0.2	-
Германи	Germany	13.7	7.6	2.4	1.9
Дани	Denmark	-	-	0.0	0.0
Их Британи	United Kingdom	3.0	18.7	13.6	11.2
Итали	Italy	5.5	11.4	14.6	14.5
Казакстан	Kazakhstan	-	34.4	0.3	1.0
Нидерланд	Netherlands	1.5	4.6	3.7	3.4
ЗХУ	USSR	517.5	-	-	-
ОХУ	Russian Federation	-	68.9	48.2	45.1
Польш	Poland	11.2	0.0	0.0	0.0
Румын	Romania	10.1	0.0	0.0	-
Сингапур	Singapore	-	1.8	0.9	0.1
Унгар	Hungary	13.7	0.0	0.0	0.0
Франц	France	2.7	0.3	0.7	1.8
БНХАУ	China	11.3	77.8	208.2	274.3
Гонконг	Hong Kong	-	3.0	-	-
Чехословак	Czechoslovakia	29.9	-	-	-
Чехийн БНУ	Czech Rep-able	-	0.4	0.1	0.0
Швейцарь	Switzerland	1.2	76.9	0.6	0.8
Япон	Japan	7.6	46.7	10.9	8.1

* 1999.01.01-нээс экспортыг хүлээн авчигч орноор тооцдог болов
* In January 1999 the exports data is defined by the recipient countries

14.3 ИМПОРТ, оны үнээр
14.3 IMPORTS, at current prices

Улсаар	By countries	1990	1995	1999	2000
Бүгд	Total	924.0	415.3	512.8	614.5
Австри	Austria	10.0	5.6	0.4	1.9
АНУ	USA	-	14.5	31.5	28.4
Афганистан	Afghanistan	0.0	0.0	-	0.7
Бельги	Belgium	0.4	0.9	2.0	2.4
Болгар	Bulgaria	17.0	0.6	3.2	3.6
Беларусь	Belarus	-	0.2	2.4	4.2
БНСУ	South Korea	0.9	21.5	36.2	55.6
БНАСАУ	North Korea	5.5	0.2	0.0	0.0
Германи	Germany	37.4	18.5	23.6	29.7
Дани	Denmark	0.1	4.1	3.0	4.4
Итали	Italy	3.6	3.6	4.5	3.0
Их Британи	United Kingdom	2.5	2.7	3.9	6.0
Казакстан	Kazakhstan	-	0.8	0.7	6.8
Нидерланд	Netherlands	0.1	0.6	1.0	2.7
ЗХУ	USSR	716.2	-	-	-
ОХУ	Russian Federation	-	208.0	149.8	206.2
Польш	Poland	-	-	4.5	4.9
Румын	Romania	-	-	-	-
Сингапур	Singapore	0.7	7.4	9.1	10.6
Гонконг	Hong Kong	2.7	6.1	-	-
Унгар	Hungary	20.5	0.5	1.4	1.7
Франц	France	2.4	1.8	8.5	8.3
БНХАУ	China	22.3	44.5	77.6	125.8
Чехословак	Czechoslovakia	34.0	-	-	-
Чехийн БНУ	Czech Republic	-	9.9	4.1	-
Швейцарь	Switzerland	5.9	6.1	2.3	3.2
Япон	Japan	9.8	45.3	115.0	73.3

Table A11: Balance of Payments (\$ million)

Item	1993	1994	1995	1996	1997
Trade Balance	-6.7	-3.5	-3.3	-7.4	-9.6
Exports (FOB)	363.8	367.0	485.6	423.3	493.7
Copper	155.1	188.7	257.6	174.5	189.1
Noncopper	210.7	178.3	228.0	248.8	294.6
Imports (CIF)	374.5	370.5	488.9	510.8	503.3
Services Balance	-31.1	-33.8	-23.4	-6.0	-4.2
Receipts	26.8	43.0	42.6	55.7	54.8
Payments	57.9	76.8	66.0	61.7	59.0
Income, Net			-22.7	-13.3	-11.1
Official Interest Payments			-9.4	-9.3	-9.3
Private Unrequited Transfers	-0.1	-3.0	-2.8	6.2	4.2
	-16.9	-40.3	-52.2	-100.5	-30.6

Хүснэгт 11. Төлбөрийн тэнцвэр

Item	1993	1994	1995	1996	1997
Торговчийн тэнцвэр	-6.7	-3.5	-3.3	-7.4	-9.6
Эхлэлтэй экспортын үнэ	363.8	367.0	485.6	423.3	493.7
Медь	155.1	188.7	257.6	174.5	189.1
Медь бусад	210.7	178.3	228.0	248.8	294.6
Эхлэлтэй импортын үнэ	374.5	370.5	488.9	510.8	503.3
Дienstleistungs Balance	-31.1	-33.8	-23.4	-6.0	-4.2
Хэргийн орлого	26.8	43.0	42.6	55.7	54.8
Хэргийн зардал	57.9	76.8	66.0	61.7	59.0
Income, Net			-22.7	-13.3	-11.1
Оффисийн хэргийн зардал			-9.4	-9.3	-9.3
Private Unrequited Transfers	-0.1	-3.0	-2.8	6.2	4.2
	-16.9	-40.3	-52.2	-100.5	-30.6

Статистик мэдээлэл бүрдүүлэх үндсэн арга хэрэгсэлийн нэг нь түүвэр судалгаа юм. Түүвэр судалгааны ач холбогдлыг нэг өгүүлбэрээр өгүүлбэл түүврийн үр дүнг тархах замаар эх олонлог буюу судлагдаж байгаа нийт үзүүлэлтийн хувьд үнэлгээ өгдөг. Манайд түүврийн тусламжтайгаар өрхийн орлого зарлагын судлагааг 2000 өрхөд хийж үр дүнг нийт өрхийн хувьд үнэлдэг. Манай улс 560 гаруй мянган өрхтэй байгаагаас үзвэл түүврийн нэгжийн тоо хангалтгүй гэж үзэхүйц байна. Гэхдээ манай улсын айл өрхүүдийн амьдралын төлөв нь бараг ижил байдаг учраас нэг өрхийн төлөөлөх чадвар өндөр гэж үзэж болно. 1999 он хүртэл өрхийг хөдөлгөөнгүй бэхэлж байсан бол одоо улирал бүр өөрчлөн судалгааг явуулж байна. Энэ нь түүврийн үр дүнг олон талаас нь үнэлэх боломж бүрдүүлж байна гэж үзэх боломжтой юм. Түүвэрийн үр дүнгээр эх олонлогийг үнэлж байгаа учраас түүвэр ажиглалт буюу мэдээллийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийн чанар онцгой үүрэгтэй. Түүвэр ажиглалтын үр дүнг сайжруулагч нэг үндэс тоологч буюу эх материал бүрдүүлэгчийн үүрэг, хариуцлага өндөр учраас түүнд тавих хяналтад анхаарах шаардлагатай. Түүвэр ажиглалтын нэг онцлог нь түүний боловсруулалт байдаг учраас мэргэжлийн ур чадвар ихээр шаардагддаг. Түүврийн объект, нэгж, мэдээлэл бүрдүүлэх арга зүйг нарийн боловсруулсан байх нь эцсийн дүгнэлтийн ач холбогдлыг өндөржүүлэх боломж нээгдэнэ.

Статистик мэдээлэлийн ач холбогдол түүнд гарах зөрчлийн талаар авч толилууллаа. Үүнийг нааштайгаар шийдвэрлэж болох санал бодлоо илэрхийлье.

1. Сумдын орлогч болон анхан шатны мэдээлэл бүрдүүлэгч нарын мэдлэг боловсролын түвшинг дээшлүүлэх талаар бодлого боловсруулан зохих арга хэмжээ авах
2. Статистик мэдээллийг бүрдүүлэх аргачлал заавар дүрмийг аль болох ойлгомжтой хэлбэрээр гаргах
3. Мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд биечлэн мэдээллийг авах хэлбэрт түлхүү анхаарах замаар мэдээллийн зөв сантай болох
4. Мэдээлэл бүрдүүлэхэд ажиглалтын объектуудын харилцан уялдааг зохистой тогтоосноор мэдээллийн давхардлыг арилгах
5. Мэдээллийн зөрүүний талаар аргчлалын, эсвэл алдааны алин болох талаар тайлбар гаргадаг хэлбэрт шилжих.

Ашигласан материал

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл 2000 он.
2. Country economic review (Mongolia) August 1998.
3. Монгол банкны тайлан 1998 он.